

## ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, НИЙГМИЙН ХАМГААЛАЛЫН БОДЛОГО

### Бодлогын мэдэгдэл ба стратегийн зорилго

Премиум Нэксус ХК болон түүний охин компаниуд (хамтад нь “Компани”) хүрээлэн буй орчныг хамгаалах, нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдлыг бүрэн хүлээн зөвшөөрч, хүрээлэн буй орчин, нийгмийн хамгааллыг хамтатган цогц бодлого болгон өөрийнхөө стратегийн шийдвэр гаргах бүхий л үйл явцууд болон өдөр тутмын үйл ажиллагаанд баримтлан ажиллана.

Энэхүү бодлого нь дараах зорилготой болно:

- Компанийн үйл ажиллагааг хүрээлэн буй орчин, нийгмийн хамгааллын олон улсын жишиг, тэр дундаа тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцүүлэх, бүх ажилтан, салбар, түнш байгууллага болон бэлтгэн нийлүүлэгчид энэхүү бодлогын хүрээнд хариуцлага хүлээж тогтвортой үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах.
- Компанийн хүрээлэн буй орчин, нийгмийн хамгааллын талаарх мэдлэг, мэдээлэл, үйл ажиллагаа, эрх үүргийг оролцогч, сонирхогч бүхий л талуудад нээлттэй, хүртээмжтэй хүргэх.
- Компанийн дотоод орчинд хүрээлэн буй орчин, нийгмийн хамгааллын мэдлэг, эрх, үүрэг хариуцлагыг сурталчлах ёс зүйтэй соёлыг бий болгох.
- Тогтвортой хөгжлийн зорилтуудад өөрийн оролцоог тодорхойлж, тогтвортой хөгжлийн үзэл санааг өөрийн зарчимтай уялдуулсан менежментийн систем бий болгож хувь нэмрээ оруулах.

### Хандлага

Компани нь үйл ажиллагаа явуулж байгаа тухайн бүс нутагт хүрээлэн буй орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давуулахгүй бөгөөд боломжит хамгийн бага төвшинд байлгах ба нийгэмд ямагт эерэг ахиу нөлөөг үзүүлэх болно.

### Үндсэн зарчим

Энэхүү бодлогын хэрэгжүүлэхдээ дараах үндсэн зарчмыг баримтална:

- Урьдчилан сэргийлэх зарчим: Нөлөөллийг гарахаас нь өмнө тодорхойлж бууруулах.
- Эрсдэлийн удирдлага: Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тогтмол үнэлж, сөрөг нөлөөллийг багасгах.
- Хууль эрх зүйн нийцэл: Үндэсний болон олон улсын хуулиудтай нийцсэн үйл ажиллагаа явуулах.
- Оролцоо, ил тод байдал: Иргэд, оролцогч талуудын дуу хоолойг сонсож, мэдээллийг ил тод байлгах.
- Тогтвортой хөгжил: Эдийн засаг, нийгэм, байгаль орчны тэнцлийг хадгалах.
- Хүний эрхийг дээдлэх: Бүх хүний эрхийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх.

### Үүрэг, оролцоо

Нийт ажилтнууд хүрээлэн буй орчин, нийгмийн хамгааллын талаарх мэдлэгтэй байж, бодлогыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах, нөлөөллийг бууруулах аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно. Компанийн удирдлагууд энэхүү бодлогыг дэмжих, бодлогын хэрэгжилтийг удирдан чиглүүлэх гол үүргийг гүйцэтгэнэ.